



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 9/343

Хэрлэн сум

Хүндэт тэмдэг олгох тухай
журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн 100 жилийн ойн “Хүндэт тэмдэг” олгох журмыг хавсралтаар баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Баярцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



231010939

Аймгийн Засаг даргын 2023
онь **06**-дугаар сарын **16**-ны
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН 100 ЖИЛИЙН ОЙН
“ХҮНДЭТ ТЭМДЭГ” ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хэнтий аймгийн 100 жилийн ойн “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулах болзол, нөхцөл, бүрдүүлэх материал, шагналд нэр дэвшүүлэх, шагналд дэвшүүлэх хүмүүсийн жагсаалтыг хүлээн авч судлах шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Шагнал олгох болзол, нөхцөл

2.1. Сум, орон нутагтаа олон жил идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй, тогтвортой ажиллаж, орон нутгийнхаа хөгжилд түүчээлэн оролцсон ахмад настан

2.2. Θөрийн эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гарган төрийн үйл хэргийг иргэд, аж ахуй нэгжид түргэн шуурхай хүргэх, ажлын бүтэээмжийг үе шаттай сайжруулахад идэвх санаачилагатай ажилласан төрийн албан хаагчид.

2.3. Төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангахад хамтран ажиллаж, аймаг орон нутгийн бүтээн байгуулалт, эдийн засагт онцгой сайн нөлөө үзүүлсэн, нийгэмд тустай үйл хийсэн иргэд.

2.4. Хэнтий аймгийн 100 жилийн ойн “Хүндэт Тэмдэг”-ийг 2023 онд багтаан шагнана.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

3.1. Хэнтий аймгийн 100 жилийн ойн “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулах Сумын иргэнийг нэр дэвшүүлэхдээ тухайн Сумын Засаг дарга тодорхойлж, аймгийн Засаг даргад өргөн мэдүүлнэ.

3.2. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн ажилтнуудыг тухайн агентлагийн /байгууллагын/ дарга тодорхойлж, аймгийн Засаг даргад өргөн мэдүүлнэ.

Дөрөв. Шагналд дэвшүүлэх хүмүүсийн жагсаалт

4.1. Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийн нэрсийг журамд заасан жагсаалтаар ирүүлнэ.

Тав. Шагналыг шийдвэрлэх

4.1 Хэнтий аймгийн 100 жилийн ойн “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулах иргэдийн материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүлээн авч шийдвэрлэнэ.

4.2 Иргэдээс ирсэн материалыг жагсаалтын дагуу архивт шилжүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2023
онь **06** дугаар сарын **16**-ны
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Хэntий аймгийн 100 жилийн ойн "Хүндэт тэмдэг"-ээр шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийн жагсаалт